



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт барьж, ашиглалтад оруулсан, нийт 8,653,385,209.00 (найман тэрбум зургаан зуун тавин гурван сая гурван зуун наян таван мянга хоёр зуун есөн) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгө (барилга байгууламж, их засвар сайжруулалт)-ийг Баянхонгор аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон үл хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны дүгээр сарын 1-ны өдрийн
1/И дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР БИЙ БОЛСОН БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨРӨН НУТГИЙН
ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Төсөл, арга хэмжээний нэр, байршил | Төсөл, арга хэмжээний хүчин чадал | Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн /төгрөгөөр/ | Улсын комиссын актын дугаар | Ашиглагч байгууллага | Гүйцэтгэгчийн нэр |
|-----|--|---|---|-----------------------------|---|-------------------|
| 1 | Ахуйн үйлчилгээний төвийн барилга, Баянхонгор сум | 27.6*14.4 м талбайтай зоорьтой 2 давхар барилга | 1,232,766,795.00 | 2019.11.11 | "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци" ХХК | "Эх бүрдэн" ХХК |
| 2 | Халуун усны барилга, Жаргалант сум | 12.0 м*10.4 м талбайтай, 1 давхар барилга | 143,370,611.00 | 2019.10.29 | Жаргалант сумын ЗДТГазар | "Бэнжцэс" ХХК |
| 3 | Хуучин Эрүүл мэндийн төвийн халаалтын засвар, | Халаалтын их засвар | 31,921,765.00 | 2019.10.25 | Бөмбөгөр сумын ЭМТөв | "Базар дарь" ХХК |
| 4 | Шинэ суурьшлын төвийн 14 ортой эмнэлгийн барилга, Баянхонгор сум | 24.2*15.8 м хэмжээтэй 2 давхар барилга | 1,011,448,568.00 | 2019.11.18 | Баянхонгор сумын Нэгдсэн эмнэлэг | "Хан халдун" ХХК |
| 5 | 15 ортой эмнэлэгийн барилга, Баянцагаан сум | 2 давхар 752м2 талбайтай | 1,183,500,000.00 | 2019.01.08 | Баянцагаан сумын Сум дундын эмнэлэг | "Жам" ХХК |

| | | | | | | |
|----------|--|--|---|------|--|-----------|
| 6 | Хонгор-1000 хорооллын дулааны шугам сүлжээ, уурын зуухны барилга, Баянхонгор сум | Дулааны Ф76-273 мм-ийн 3000 м, хэрэгцээний халуун усны Ф48-165 мм-ийн 3000 м шугам, Хүйтэн усны Ф63-165 мм-ийн 1738 м, бохир усны Ф160-315 мм-ийн 2047 м шугам, 81 ш төмөр бетон худаг, ХТП-ийн 3 ш барилга, 6 квт-ын 400 м шугам, УДДТөв, тогооны барилга, DZL-2.8-0.7 маркийн 3 ш, DZL- 1,4-0,7 маркийн 1 ш тогоо бүхий халаалтын зуух | 5,050,377,470.00 | 2018 | Баянхонгор сумын "Тохжилт үйлчилгээ" ОНӨААТҮГ | "Сан" ХХК |
| Нийт дүн | | | 8,653,385,209.00 (найман тэрбум зургаан зуун тавин гурван сая гурван зуун наян таван мянга хоёр зуун есөн) | | | |